



“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024 - 07 - 17 № 01/1310
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай компаниас зарласан “Тавантолгой ордыг цогц, иж бүрнээр ашиглах ТЭЗҮ боловсруулах” ЭТТХК/20240103100 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Ди ди эй жи” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1.5-д “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана” Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй орд ашиглах ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагатай байна...Ижил төстэй ажилд орд ашиглах ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагыг тооцно.” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Захиалагч техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.” гэж, 17.2.2-т “бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/260 дугаар тушаалаар баталсан “Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн 19.1-д “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Жишээ: батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [●] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг ТШЗ 17.2-т заасан хугацаанд доод тал нь [●] удаа байх. Захиалагч ижил төстэй үйлчилгээг тухайлан зааж болно.]” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1 дэх шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана” Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 30

0002890

хувиас багагүй үнийн дүнтэй орд ашиглах ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагатай байна...Ижил төстэй ажилд орд ашиглах ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагыг тооцно.” гэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА  Б.БИЛГҮҮН